



Хэвлэлийн мэдээ

2016 оны 8-р сарын 16-ны өдөр

Холбогдох утас:

9710-9009

“Америкийн Өдрүүд 2016” Үзэсгэлэн Худалдаа Гурав дахь Жилдээ Болно

УЛААНБААТАР, МОНГОЛ УЛС - Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол)-аас гурав дахь жилдээ “Америкийн өдрүүд” үзэсгэлэн худалдааг Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран 2016 оны 9-р сарын 24, 25-ны өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулах гэж байна. Энэхүү 2 өдрийн үзэсгэлэн худалдаа нь АНУ-ын бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд нэг цэгээс танилцуулах, Монгол улсад дэлхийн чанар, стандартыг нэвтрүүлэн ажиллаж буй компаниудын үйл ажиллагааг дэмжих, хэрэглэгчдэд ойртуулах зорилготой.

2015 оны Америкийн Өдрүүд үзэсгэлэн худалдаанд 80 гаруй аж ахуйн нэгж оролцож, арван мянга орчим зочид ирж сонирхсон ба 2016 онд бид амжилтаа ахиулахаар ажиллаж байна. “Америкийн өдрүүд” үзэсгэлэн худалдаа нь Америкийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулдаг бүхий л аж ахуйн нэгж, байгууллагуудад нээлттэй.

Америкийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулдаг АмЧамын гишүүн байгууллагууд 9 м² бүхий өргөтгөсөн павильон үнэ төлбөргүй авах боломжтойгоос гадна павильоны түрээсийн хөнгөлөлттэй үнэ 2016 оны 8-р сарын 31-ний дуустал үргэлжилнэ. Мөн үзэсгэлэн худалдаанд хоёр дахь удаагаа оролцож буй байгууллагууд түрээсийн үнийн дүнгээс 10% хөнгөлөлт эдлэх боломжтой. Үзэсгэлэнд оролцсоноор дараах ховор боломжуудыг эдлэх болно. Үүнд:

- Бүтээгдэхүүн үйлчилгээгээ худалдан авагч, хэрэглэгч, бизнесийн төлөөлөгчдөд хүргэх, борлуулах
- Байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулах, олон нийтэд хүргэх
- Шинэ бизнесийн боломж, түнш олох
- Үзэсгэлэн худалдааны нэгдсэн хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцож, компанийн үйл ажиллагааг ирэх зочдод танилцуулах, өөрийн компанийн нэрэмжит хөтөлбөр зохиох

| ХӨНГӨЛӨЛТТЭЙ ҮНЭ | |
|--|--|
| Өргөтгөсөн павильон 550,000 ₮ (2 өдөр) | Стандарт павильон 300,000 ₮ (2 өдөр) |
| <ul style="list-style-type: none">• 9 м² павильон• 1 ширээ (120x80)• 3 сандал• Цахилгаан• 2 гэрэл• Давуу байрлал | <ul style="list-style-type: none">• 6 м² павильон• 1 ширээ (120x80)• 2 сандал• Цахилгаан• 2 гэрэл |

Бүртгэлийн хугацаа 2016.09.16-ныг дуустал үргэлжлэх ба үзэсгэлэнд оролцохыг хүссэн байгууллагууд Англи болон Монгол хэл дээр бүртгэлийн хуудсыг бөглөх боломжтой. АмЧамын гишүүн байгууллагуудад ивээн тэтгэгч болох боломж нээлттэй ба үзэсгэлэнгийн талбай хязгаартай. Дэлгэрэнгүй мэдээллийг munkhjargal@amcham.mn болон 99997104; 7000 3437 утсаар авах боломжтой.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны оффис юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.